БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2023/125/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: кhuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: У.Ербол<br>Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

**АГУУЛГА**

1.**ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** .......... 4
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** .......... 6
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** .......... 15
**4. АУДИТЫН ТАЙЛАН** .......... 19
**4.1 Ерөнхий зүйл** .......... 19
**4.2 Материаллаг байдал** .......... 19
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** .......... 19
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** 19
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** .......... 19
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** .......... 20
**4.5.1 Завсрын аудитын талаар** .......... 20
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** .......... 21
**5.1 Төлбөрийн акт** .......... 21
**5.2 Албан шаардлага** .......... 21
**5.3 Зөвлөмж** .......... 21
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** .......... 22

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2023.02.24 № 120
танай ______ -ны № ______ -т

ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А.ЖАНАЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийхдээ 680.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 104.7 сая төгрөгийн бараа материалын тооллогын дүнг гаргаагүй, тооллогын дүнгээр үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй, 3.7 сая төгрөгийн түрээсийн орлогыг бүрдэл дутуу баримтаар зарцуулсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 12 дугаар зүйлийн 12.1, 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-ийн 1,2, 71 дүгээр зүйлийн 1-ийн 2 заалт, УСНББОУС 1, 12, 17 стандартын заалтуудад нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сургуулийн 2022 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлог асуудал байхгүй.

**Аудитын гол асуудал**

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **102,986,963.90** | **121,736,695.90** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 15,372,614.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 15,372,614.00 |
| **3121** | **Төгрөг** | - | 15,372,614.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 15,372,614.00 |
| **33** | **АВЛАГА** | 1,164,458.00 | 1,137,616.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,164,458.00 | 1,137,616.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 101,822,505.90 | 105,226,465.90 |
| **354** | **Хангамжийн материал** | 101,822,505.90 | 105,226,465.90 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 553,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,084,200.00 | 5,935,160.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 98,738,305.90 | 98,738,305.90 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,961,258,946.46** | **1,982,212,730.93** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,961,258,946.46 | 1,982,212,730.93 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,754,366,946.46 | 1,775,320,730.93 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,845,948,850.18 | 1,845,948,850.18 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (332,896,225.93) | (409,157,395.45) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 24,750,000.00 | 24,750,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (3,712,500.00) | (6,187,500.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 230,108,628.47 | 333,923,438.47 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (211,879,079.83) | (219,230,309.53) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 127,369,748.36 | 131,211,748.36 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (97,087,565.94) | (100,707,284.93) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 61,644,200.00 | 61,644,200.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (33,516,666.43) | (39,520,666.39) |
| 39217 | Ном | 143,637,557.58 | 152,645,650.22 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 206,892,000.00 | 206,892,000.00 |
| 39301 | Програм хангамж | 750,000.00 | 750,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (750,000.00) | (750,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 206,892,000.00 | 206,892,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,064,245,910.36** | **2,103,949,426.83** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **31,032,286.00** | **129,748,108.13** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 31,032,286.00 | 129,748,108.13 |
| **413** | **Өглөг** | 31,032,286.00 | 129,748,108.13 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 1,847,164.53 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 31,032,286.00 | 127,900,943.60 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,033,213,624.36** | **1,974,201,318.70** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,033,213,624.36 | 1,974,201,318.70 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 933,880,457.00 | 933,880,457.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 933,880,457.00 | 933,880,457.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (275,463,517.91) | (334,475,823.57) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (275,463,517.91) | (275,463,517.91) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (59,012,305.66) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,374,796,685.27 | 1,374,796,685.27 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,064,245,910.36** | **2,103,949,426.83** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,201,832,970.50** | **2,646,787,502.64** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **629,617.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 629,617.00 | - |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 629,617.00 | - |
| 1E+06 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 629,617.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,201,203,353.50** | **2,646,787,502.64** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,979,573,638.50 | 2,367,774,902.64 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 2,335,245,600.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 11,821,638.50 | 32,529,302.64 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,967,752,000.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11,664,915.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,664,915.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 209,964,800.00 | 279,012,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 209,144,800.00 | 279,012,600.00 |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | - | - |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | 820,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,281,993,548.17** | **2,705,799,808.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,281,993,548.17** | **2,705,799,808.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,226,693,848.17 | 2,589,875,308.30 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,621,366,353.00 | 1,887,631,022.53 |
| 210101 | Үндсэн цалин | 1,513,172,353.00 | 1,485,157,407.10 |
| 210102 | Нэмэгдэл | | 366,884,515.43 |
| 210104 | Урамшуулал | 108,194,000.00 | 35,589,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 217,611,742.00 | 233,983,884.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 152,966,942.00 | 158,744,884.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,161,200.00 | 18,809,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,929,000.00 | 15,047,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,232,200.00 | 3,761,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 32,322,400.00 | 37,619,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 207,644,800.00 | 308,903,457.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,431,900.00 | 3,650,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 189,940,000.00 | 289,698,657.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,272,900.00 | 15,554,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,034,068.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 1,596,000.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,204,700.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,173,251.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 657,900.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 25,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,377,217.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 2,464,600.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 384,100.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,080,500.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,237,849.00 | 766,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,237,849.00 | 766,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 672,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 672,000.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 373,000.00 | 5,272,686.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 373,000.00 | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 5,272,686.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 143,289,436.17 | 153,317,958.17 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,239,000.00 | 31,198,340.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 46,355,415.00 | 26,408,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 94,695,021.17 | 95,711,118.17 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 55,299,700.00 | 115,924,500.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 52,554,400.00 | 115,924,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 52,554,400.00 | 115,924,500.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,745,300.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,745,300.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(80,160,577.67)** | **(59,012,305.66)** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(80,160,577.67)** | **(59,012,305.66)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,188,561,715.00** | **2,614,258,200.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,188,561,715.00** | **2,614,258,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,967,752,000.00 | 2,335,245,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 2,335,245,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,967,752,000.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11,664,915.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,664,915.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 209,144,800.00 | 279,012,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 209,144,800.00 | 279,012,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,185,862,715.00** | **2,514,749,986.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,185,862,715.00** | **2,514,749,986.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,130,563,015.00** | **2,399,052,086.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,619,919,700.00 | 1,884,619,400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,511,725,700.00 | 1,485,978,300.00 |
| 210102 | Нэмэгдэл | | 363,052,000.00 |
| 210104 | Урамшуулал | 108,194,000.00 | 35,589,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 218,176,200.00 | 235,121,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 153,531,400.00 | 159,882,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,161,200.00 | 18,809,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,929,000.00 | 15,047,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,232,200.00 | 3,761,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 32,322,400.00 | 37,619,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 207,644,800.00 | 212,034,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,483,800.00 | 3,983,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 189,940,000.00 | 192,830,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 14,221,000.00 | 15,221,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 32,094,615.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 1,512,215.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,204,700.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,123,700.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | 519,800.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 350,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,384,200.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 2,246,800.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 284,500.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,962,300.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,500,000.00 | 1,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,500,000.00 | 1,600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 672,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 672,000.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 981,100.00 | 6,187,686.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 981,100.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 6,187,686.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 47,327,800.00 | 59,488,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,409,500.00 | 34,818,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 36,918,300.00 | 24,669,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **55,299,700.00** | **115,697,900.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 52,554,400.00 | 115,697,900.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 52,554,400.00 | 115,697,900.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,745,300.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,745,300.00 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2,699,000.00** | **99,508,214.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2,699,000.00** | **84,135,600.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,699,000.00** | **84,135,600.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,699,000.00 | 84,135,600.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,699,000.00 | 84,135,600.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(2,699,000.00)** | **(84,135,600.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 15,372,614.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 15,372,614.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | | | | 0.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** | 0.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | 0.00 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** | 0.00 |
| D01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 933,880,457.00 | 1,374,796,685.27 | -275,463,517.91 | | 2,033,213,624.36 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 933,880,457.00 | 1,374,796,685.27 | -275,463,517.91 | | 2,033,213,624.36 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **933,880,457.00** | **1,374,796,685.27** | **-275,463,517.91** | **0.00** | 2,033,213,624.36 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -59,012,305.66 | | -59,012,305.66 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **933,880,457.00** | **1,374,796,685.27** | **-334,475,823.57** | **0.00** | 1,974,201,318.70 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,614,258,200.00 | 2,598,885,586.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,614,258,200.00 | 2,598,885,586.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,491,623,900.00 | 2,483,187,686.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,884,619,400.00 | 1,884,619,400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,485,978,300.00 | 1,485,978,300.00 |
| 210102 | Нэмэгдэл | 363,052,000.00 | 363,052,000.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 35,589,100.00 | 35,589,100.00 |
| 210104 | Урамшуулал | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 235,121,500.00 | 235,121,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 159,882,500.00 | 159,882,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18,809,700.00 | 18,809,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,047,800.00 | 15,047,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,761,900.00 | 3,761,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 37,619,600.00 | 37,619,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 212,034,800.00 | 212,034,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,983,800.00 | 3,983,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 192,830,000.00 | 192,830,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,221,000.00 | 15,221,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,600,000.00 | 1,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,600,000.00 | 1,600,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,496,600.00 | 13,377,686.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16,496,600.00 | 13,377,686.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 141,751,600.00 | 136,434,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 117,006,700.00 | 111,689,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 24,744,900.00 | 24,744,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 122,634,300.00 | 115,697,900.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 122,634,300.00 | 115,697,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 122,634,300.00 | 115,697,900.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,614,258,200.00 | 2,598,885,586.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,335,245,600.00 | 2,319,872,986.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,335,245,600.00 | 2,335,245,600.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 279,012,600.00 | 279,012,600.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 279,012,600.00 | 279,012,600.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 15,372,614.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 135 | 138 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 106 | 109 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 28 | 28 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 998 | 1,407 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 998 | 1,407 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 998 | 1,407 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **135** | **138** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 100 | 103 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 2 | 2 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1 | 1 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 32 | 32 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

# 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

### Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн зорилгыг “хүүхэд бүрийн сурах үйлийг дэмжиж, нийгэм, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэн тэдний хөгжил, төлөвшил, сурлагын амжилт чанарт ахиц гаргах, багш бүр мэргэжлээрээ тасралтгүй хөгжих, хамтран суралцах боломжийг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

1. Багшийн ажлыг гүйцэтгэлийн үр дүнд суурилан мэргэжлээрээ тасралтгүй хөгжих, хамтран ажиллах, суралцах, мэргэжлийн бүлэг байгуулан ажиллах боломжийг бүрдүүлэх,
2. Сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэн хүүхэд хамгааллыг сайжруулах, хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх,
3. Суралцагч бүрийн сурлагын амжилтыг ахиулахад анхаарч, улирал бүр түвшин тогтоох шалгалт авч үр дүнг тооцож байх,
4. Ахлах ангийн сурагчдын мэргэжил сонголт, сонгон суралцах хичээлийг чанартай зохион байгуулан ахиц гаргах,
5. Сургуулийн багш, ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг чанд сахин хамт олноороо харилцааны эерэг хандлага, соёл төлөвшүүлэх,
6. Улсын хэмжээний цахим хичээлийн сан бүрдүүлэх зорилгоор ажиллуулж буй medle.mn сайтад 5-аас доошгүй хичээл байршуулах,
7. Хичээлийн хоцрогдлыг арилгах, тусгай төлөвлөгөө гарган ажиллуулах.

## 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

### Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзэв.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.Тайлант онд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургуулийн захирлын 2021 оны А/11 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | 15,372,6 | - 15,372,6 |
| Авлага | 1,164,4 | 1,137,6 | -26.8 |
| Бараа материал | 101,822,5 | 105,226,5 | 3,404.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,961,258,9 | 1,982,212,7 | 20,953.8 |
| **Нийт хөрөнгө** | **2,064,245,9** | **2,103,949,4** | **39,703.5** |

| | | | |
|---|---|---|---|
| Өр төлбөр | 31,032,3 | 129,748,1 | 98,715.8 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,033,213,6 | 1,974,201,3 | -59,012.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,064,245,9** | **2,103,949,4** | **39,703.5** |

Жилийн эцэст 15,4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн хөрөнгийн үлдэгдэлтэй гарч, авлагын данс 0.02 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын данс 3.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аж ахуйн материал худалдаж авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 20.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр худалдаж авсан үндсэн хөрөнгө 84.1 сая төгрөг, БШУЯ-наас нийлүүлсэн 22.1 сая төгрөг, аймгийн Боловсролын газраас нийлүүлсэн 8.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөр нэмэгдэж, элэгдлийн зардлын 95.7 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Өр төлбөрийн данс 98.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь түлш халаалтын өр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 39.7 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Аудит хийх явцад төсвийн төлөвлөлтийн талаар баримт материал ирүүлээгүй. /Тухайн үед онлайнаар төсвийн санал өгсөн гэсэн тайлбар өгсөн/

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Тайлант онд төсвийн тодотгол хийгдэж улсын төсвөөс санхүүжих зардлыг 2335.2 сая төгрөгөөр баталж анх баталсан төсвөөс 152.8 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2335.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 279.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2319.8 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 279.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 15.3 сая төгрөгийг жилийн эцсийн үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2598.8 сая төгрөг буюу 99.4 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/сая төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Байр ашиглалтын үйлчилгээ | 6.6 | 6.6 | 0 | 100% |
| 2 | Сургалт семинар | 3.2 | 1.7 | 1.5 | 53.1% |
| 3 | Эрүүл мэндийг дэмжих | 7.6 | 7.6 | 0 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | үдийн цай хөтөлбөр | 122.6 | 115.7 | 6.9 | 94.3% |
| 5 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 76.4 | 76.3 | 0.1 | 99.9% |
| 6 | Боловсролын байгууллагын багш | 14.8 | 11.1 | 3.7 | 75% |
| 7 | Боловсролын стандарт | 1948,5 | 1945,4 | 3.0 | 99.8% |
| 8 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 155,4 | 155,4 | 0 | 100% |
| 9 | Нийтлэг үйлчилгээ | 279,0 | 279,0 | 0 | 100% |
| | **Дүн** | **2614.1** | **2598.8** | **15.3** | **99.4%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр гүйлгээ гараагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийллэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 09 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийлллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2281.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 22.8 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус сургууль нь улсын төсвийн санхүүжилтийн хэмнэсэн 15.3 сая төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд зориулан 1.3 сая төгрөгийг шагнал, бэлэг дурсгалд, 1.4 сая төгрөгийг багш нарын биеийн тамирын хувцас авч үр ашиггүй зардал гаргаж, зарлага гаргаж Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуул нь 2022 онд нийт 876.0 сая төгрөгийн 32 мэдээллийг Шилэн дансны нэгдэн цахим хуудаст ил тод байршуулахаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний 494.5 сая төгрөгийн 12 мэдээллийг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний 181.3 сая төгрөгийн 10 мэдээллийг байршуулаагүй, Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 37.8 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төвлөрсөн халаалтын зардалтай холбоотой нийт 67.1 сая төгрөгийн өглөгийг хүлээн зөвшөөрч баталгаажуулаагүй, үдийн цай 41.8 сая төгрөгийн, бусад зардал 4.6 сая төгрөгийн нийт 46.5 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

мянган төгрөг

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 2 | 113527.2 | 2 | 113527.2 | **100%** |
| **Нийт дүн** | **2** | **113527.2** | **2** | **113527.2** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул, гүйцэтгэлийн аудитаар цалингийн зардал болон бусад зардлуудыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгдээгүй байна.

Аудитаар нийт 1584.3 сая төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 1.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1582.8 сая төгрөгийн 4 зөрчилд дөрвөн албан шаардлага хүргүүлсэн болно.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитын дүнгээр дараах зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1.Сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн албан тушаалтны цалинг тооцож олгохдоо томилсон эрх бүхий этгээдийн захирамжийг зөрчиж, үндсэн цалингийн 40 хувийн нэмэгдлийг давхар олгож нийт 1.5 сая төгрөгийн цалинг илүү олгосныг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр дараах зөрчлүүдэд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1.Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийгдсэн боловч 680.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө /барилга, тээврийн хэрэгслийг хасаж тооцов/, 104.6 сая төгрөгийн бараа материалын тооллогын дүнг гаргаагүй, тооллогын комиссын гишүүд гарын үсэг зурж хөрөнгийн үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй.

2.Тайлант онд үдийн хоолны зардалд нийт 77,232 сурагчдад 115.7 сая төгрөгийг зарцуулсан боловч зөвхөн сургалтын менежерийн тайланг үндэслэн олгож, зарцуулалтын тайланд захирал, нягтлан бодогч, холбогдох бусад албан тушаалтнууд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, сургуулийн цайны газрыг түрээслэгч “үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч “Ах дастархан” ХХК-тай нийт 3.7 сая төгрөгийн түрээсийн төлбөр төлөхөөр гэрээ байгуулж, төлбөрийг бэлнээр авч бүрдэл дутуу баримтаар зарцуулсан.

3.Байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд зориулан 1.3 сая төгрөгийг шагнал, бэлэг дурсгалд, 1.3 сая төгрөгийг багш нарын биеийн тамирын хувцас авч үр ашиггүй зардал гаргасан.

4. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 876.6 сая төгрөгийн 32 мэдээллийг ил тод байршуулахаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний 494.5 сая төгрөгийн 12 мэдээллийг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний 181.3 сая төгрөгийн 10 мэдээллийг байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 37.8 хувьтай байна.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хууль тогтоомж зөрчиж илүү олгосон үр дүнгийн урамшуулал | 1 | 1523.5 | 1 | 1523.5 | | | | | | | | |
| Хөрөнгийн тооллого дутуу хийсэн | 1 | 784,848.4 | | | 1 | 784,848.4 | | | | | | |
| Үдийн хоолны зардлыг хяналтгүй зарцуулсан, түрээсийн төлбөрийг авлагаар бүртгээгүй | 1 | 119,420,8 | | | 1 | 119,420,8 | | | | | | |
| **Дүн** | **3** | **905,792.7** | 1 | 1523.5 | **2** | 904,269.2 | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ | 1 | 675,794.3 | | | 1 | 675,794.3 | | |
| Дүн | 1 | 675,794.3 | | | 1 | 675,794.3 | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Хууль тогтоомж зөрчин шагнал олгосон, биеийн тамирын хувцас авч, зарлага гаргасан | 1 | 2696.0 | | | 1 | 2696.0 | | |
| Дүн | 1 | 2696.0 | | | 1 | 2696.0 | | |
| **Нийт дүн** | **2** | **678,490.3** | | | **2** | **678,490.3** | | |